



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 21

Мандалговь

**Хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 4 дэхь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Өлзийт сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 20,000,000.00 /Хорин сая төгрөг/-ний анхны өртөгтэй 34 тэмээг Аймгийн Засаг даргын тамгын газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг зохих хууль журмын дагуу байгууллагын данс бүртгэлээс хасахыг Өлзийт сумын Засаг даргын тамгын газрын дарга /Б.Хорлоо/-д, бүртгэж авахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга /Ц.Эрдэнэсүрэн/-д тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцэцэгид үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

0100050